



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.3, 35.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах журам"-ыг нэгдүгээр, "Хүүхдийн цэцэрлэгийн болон багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур"-ыг хоёрдугаар, "Ерөнхий боловсролын сургуулийн болон багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосугай.

2.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, үнэлгээг чанартай зохион байгуулахыг Боловсролын үнэлгээний төв (Э.Цэрэнцоодол)-д;

2.2. Журмыг багш, албан хаагчдад таниулах, байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх үйл ажиллагааг чанартай зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, дүүргийн боловсролын хэлтсийн дарга, цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт.

3. Журмын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/115 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1428010097

Боловсролын сайдын 2026 оны 04
сарын 27-ны өдрийн А/27
тушаалын нэгдүгээр хавсралт

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГА, БАГШИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага /цаашид “цэцэрлэг, сургууль” гэх/, багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэхтэй холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ /цаашид “гүйцэтгэлийн үнэлгээ” гэх/-ний зорилго нь боловсролын үйлчилгээний чанар, багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулахад чиглэсэн мэргэжлийн дэмжлэгийг байгууллага, багшид үзүүлэхэд чиглэнэ.

1.3. Гүйцэтгэлийн үнэлгээ нь хууль тогтоомжид нийцсэн, ил тод, нээлттэй, шударга, нотолгоонд суурилсан, байгууллага болон багшийн нэр хүндийг хүндэтгэсэн, талуудын оролцоог тэгш хангасан, үнэлгээний олон арга хэлбэрийг хослуулсан, үнэлгээний үр дүн нь бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байна.

1.4. Гүйцэтгэлийн үнэлгээ нь хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт заасан чиг үүргийн хүрээнд байгууллага болон багшийн тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлнэ.

1.5. Энэ тушаалын хоёр, гуравдугаар хавсралтад заасан шалгуурыг баримтлан байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.

1.5.1. “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн” шалгуурыг боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага (цаашид “Боловсролын үнэлгээний төв” гэх) хөндлөнгөөс зохион байгуулна.

Хоёр. Гүйцэтгэлийн үнэлгээний зохион байгуулалт

2.1. Гүйцэтгэлийн үнэлгээг Боловсролын үнэлгээний төв үндэсний хэмжээнд нэгдсэн арга зүй, удирдамжаар хангаж ажиллана.

2.2. Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг Боловсролын үнэлгээний төв аймаг, нийслэлийн боловсролын газартай хамтран зохион байгуулна.

2.3. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг тухайн цэцэрлэг, сургууль зохион байгуулах бөгөөд багшийн албан тушаалын үндсэн орон тоонд тухайн хичээлийн жилд 6-аас дээш сар ажиллаж байгаа багш үнэлгээнд хамрагдана.

2.4. Боловсролын үнэлгээний төв нь энэ журмын 2.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

2.4.1. Гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулахтай холбогдох саналыг жил бүрийн нэгдүгээр сард багтаан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2.4.2. Гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах удирдамж, аргачлалыг баталж, аймаг, нийслэлийн боловсролын газраар дамжуулан цэцэрлэг, сургуульд хүргүүлэх, сургалт зохион байгуулах;

2.4.3. тухайн жилд зохион байгуулах гүйцэтгэлийн үнэлгээний арга хэрэгслийг энэ тушаалын хоёр, гуравдугаар хавсралтад заасан үнэлгээний шалгуур, сургалтын хөтөлбөр, байгууллага, хүний нөөцийн хөгжил, ёс зүй, суралцагчийн хөгжил, хамгаалал болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн боловсруулж, тохирц, нийцлийг ханган ажиллах;

2.4.4. энэ журмын 2.6.2-т заасан мэдээлэл цуглуулах, хянан баталгаажуулах ажлыг зохион байгуулахад аймаг, нийслэлийн боловсролын газрыг арга зүйн удирдлагаар хангах;

2.4.5. энэ тушаалын хоёр, гуравдугаар хавсралтад заасан "Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн" шалгуурыг үнэлэх үнэлгээний даалгавар боловсруулах, тохирц, нийцлийг шалгах, баталгаажуулах, үнэлгээнд хамрагдах суралцагчийн түүвэр тогтоох, бичгийн шалгалт (цахим)-ыг зохион байгуулах, үр дүнг боловсруулах, тайлагнах;

2.4.6. гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, үнэлгээний тохирц, найдвартай байдал болон холбогдох бусад шинжилгээ хийж, үр дүнг баталгаажуулан үнэлгээ зохион байгуулснаас хойш гурван сарын дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

2.4.7. мэдээллийн системд байршсан гүйцэтгэлийн үнэлгээний дэлгэрэнгүй үр дүнтэй танилцах, шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх;

2.4.8. тухайн жилд зохион байгуулсан гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагатай хамтран шинжилгээ хийж, нэгдсэн тайлан боловсруулж, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх;

2.4.9. сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний явц, үр дүн, тайланд үндэслэн үнэлгээний арга хэрэгсэл, удирдамж, аргачлалыг боловсронгуй болгох.

2.5. Боловсролын салбарын мэдээллийн системийн нэвтрүүлэлт, хөгжүүлэлт хариуцсан байгууллага энэ журмын 2.4.4-д заасан мэдээллийг бүрдүүлэх, шаардлагатай суурь мэдээлэл солилцоход Боловсролын үнэлгээний төвтэй хамтран ажиллана.

2.6. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулахад дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.6.1. энэ журмын 2.4.2-т заасан удирдамж, аргачлалыг мөрдөн ажиллах;

2.6.2. тухайн хичээлийн жилд ажиллаж байгаа багш бүрийн мэдээллийг үнэн зөв бүрдүүлэх чиглэлээр цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтныг мэргэжил арга зүйгээр хангаж, Боловсролын үнэлгээний төвөөс тогтоосон хугацаанд хянан мэдээллийн системд баталгаажуулах;

2.6.3. гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулахад баримтлах дэг, цэцэрлэг, сургуулийн үнэлгээний багт зориулсан зөвлөмжийг энэ журмын 2.4.2-т заасан удирдамжид үндэслэн боловсруулж хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

2.6.4. сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах, хөндлөнгийн хяналт тавих ажилтныг томилж ажиллуулах;

2.6.5. гүйцэтгэлийн үнэлгээний мэдээлэл цуглуулах ажлын явцын тэмдэглэл хөтлөх, тайлан бичих талаар энэ журмын 2.6.3, 2.6.4-т заасан үнэлгээний баг, ажилтныг тус тус арга зүйгээр хангах;

2.6.6.сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулсан үнэлгээний багийн тайланг энэ журмын 2.4.2-т заасан удирдамж, аргачлалыг сайжруулах саналын хамт Боловсролын үнэлгээний төвд хүргүүлэх;

2.6.7.Боловсролын үнэлгээний төвөөс ирүүлсэн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мэдээллийг цэцэрлэг, сургуульд хүргэх, байгууллага болон багшийн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, багш, ажилтны хамтын ажиллагаа, мэргэжлийн хөгжлийг дэмжих зөвлөмж, арга зүйгээр хангаж ажиллах.

2.7.Гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулахад цэцэрлэг, сургуулийн удирдлага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.7.1.багшийн гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах үнэлгээний багийг томилох;

2.7.2.үнэлгээний багийн гишүүдийг багш нарын зөвлөлийн хурлаар нээлттэй нэр дэвшүүлэн хэлэлцэж, хуралд оролцогчдын олонх нь нэр дэвшигчийг дэмжсэн тохиолдолд шийдвэрийг хүчинтэйд тооцох;

2.7.3.цэцэрлэг, сургуулийн онцлог, багшийн тооноос хамааран үнэлгээний баг 3-15 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд 3 ба түүнээс дээш хичээлийн байртай тохиолдолд 5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй дэд баг байгуулах;

2.7.4.үнэлгээний баг Боловсролын ерөнхий хуулийн 35.3-т заасан төлөөллийн оролцоог хангасан байх;

2.7.5.үнэлгээний багийн гишүүдтэй хариуцлагын гэрээ байгуулах, дүгнэх;

2.7.6.багш бүрийн холбогдох мэдээллийг мэдээллийн системд хянаж, заасан хугацаанд баталгаажуулах;

2.7.7.үнэлгээний багийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай дэмжлэг үзүүлэх.

2.7.8.энэ тушаалын хоёр, гуравдугаар хавсралтад заасан шалгуур болон удирдамж, аргачлалын дагуу багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, тайланг тогтоосон хугацаанд аймаг, нийслэлийн боловсролын газарт хүргүүлэх.

2.8. Цэцэрлэг, сургуулийн үнэлгээний баг нь гүйцэтгэлийн үнэлгээг доор дурдсаны дагуу зохион байгуулна.

2.8.1.гүйцэтгэлийн үнэлгээг батлагдсан удирдамж, аргачлалын дагуу үнэн зөв, шударга зохион байгуулах, ашиг сонирхлын зөрчилгүй болохоос илэрхийлсэн мэдэгдэл, хариуцлагын гэрээг сургалтын байгууллагын удирдлагатай байгуулах;

2.8.2.гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулахтай холбоотой батлагдсан дүрэм, журам, удирдамжийг багш нарт нэгдсэн зохион байгуулалттайгаар танилцуулж, тэмдэглэл хөтлөх;

2.8.3.байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний асуулгад суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хөндлөнгийн нөлөөлөлгүй хариулах орчин, нөхцөл бүрдүүлэх;

2.8.4.удирдамжийн дагуу байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний мэдээлэл цуглуулж, багшийн гүйцэтгэл, үр дүнг нотолгоонд суурилан үнэлж дүгнэн мэдээллийн системд оруулах.

2.9.Цэцэрлэг, сургууль нь багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд энэ журмын 2.4.6-д заасан бичгийн шалгалт (цахим)-ын үр дүнг ашиглана.

2.10. Хүүхдийн цэцэрлэгийн бага, дунд бүлгийн болон хөгжим, биеийн тамирын багшийн хувьд энэ тушаалын хоёрдугаар хавсралтын "Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур"-ын 1.1 дэх үзүүлэлтийг тухайн багшийн сургалт, үйл ажиллагааны явцад бүрдүүлсэн баримт нотолгоог үндэслэн тооцно.

2.11. Энэ тушаалын гуравдугаар хавсралтын "Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур"-ын 1.1 дэх үзүүлэлтийг 1-2 дугаар анги удирдсан багшийн хувьд суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц, амжилтыг үнэлсэн оношлох, явцын үнэлгээ болон сургуулийн хөндлөнгийн үнэлгээгээр тооцно.

2.12. Үнэлгээний багийн гишүүд үнэлгээний баримт нотолгоог хуурамчаар үйлдсэн, асуулгад оролцож байгаа багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдад нөлөөлж үнэлгээний дүн бодитой бус гарахад хүргэсэн нь үнэлгээний явц, үнэлгээнд оролцогчдоос ирүүлсэн санал, гомдол болон үр дүнд хийсэн шинжилгээгээр нотлогдсон тохиолдолд тухайн байгууллагын үнэлгээг Боловсролын үнэлгээний төв, багшийн үнэлгээг тухайн байгууллага хүчингүйд тооцно.

Гурав. Сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг тооцох, ашиглах

3.1. Боловсролын үнэлгээний төв нь гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр цэцэрлэг, сургуулийг сум-баг, аймгийн төв, нийслэл гэсэн 3 байршил /цаашид "кластер" гэх/-аар доор дурдсан индексийн 5 түвшинд эрэмбэлж, үр дүнг системд байршуулна:

Индексийн түвшин	Тухайн кластер дахь сургалтын байгууллагын эрэмбийн хувь N
I түвшин	$95 \leq N$
II түвшин	$85 \leq N < 95$
III түвшин	$70 \leq N < 85$
IV түвшин	$60 \leq N < 70$
V түвшин	$N < 60$

3.2. Сургалтын байгууллагын эрэмбийн хувь N гэдэгт тухайн кластер дахь сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, тархалтын дунджаас хэдэн хувиас дээгүүр байрлаж байгааг илэрхийлэх хувь /проценталь хувь/ байна.

3.3. Байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг багш, цэцэрлэг, сургууль, боловсролын бусад байгууллага дараах байдлаар ашиглана.

3.3.1. Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж байгууллагын менежмент, багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, чадамжийг хөгжүүлэх;

3.3.2. Аймаг, нийслэлийн боловсролын газар нь тухайн орон нутгийн цэцэрлэг, сургууль, багшийн хөгжлийн хэрэгцээ, сургалт, үйл ажиллагааны үр дүнг тодорхойлж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг орон нутгийн түвшинд төлөвлөн хэрэгжүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;

3.3.3. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, чанар, үр дүнд шинжилгээ хийж холбогдох зөвлөмжийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор хүргүүлэх.

3.4.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.4.1.Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн холбогдох урамшууллыг олгох;

3.4.2.Сургалтын байгууллага, багшийн хэрэгцээнд үндэслэн хичээл, сургалт, үйл ажиллагааг ерөнхий зохион байгуулалтаар хангах, санхүүжилтийг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд аймаг, нийслэлийн боловсролын газарт арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, холбогдох талуудын оролцоог ханган зохион байгуулах;

3.4.3.Тухайн хичээлийн жилд зохион байгуулсан байгууллага, багшийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааны явц, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авах.

Дөрөв. Бусад

4.1.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Боловсролын үнэлгээний төв, аймаг, нийслэлийн боловсролын газрын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан болон гүйцэтгэх албан тушаалтан, сургалтын байгууллагын удирдах ажилтан, үнэлгээний багийн гишүүд нь байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх бүх үе шатанд мэдээллийн систем дэх үр дүнгийн болон мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.

4.2.Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мэдээллийг энэ журамд зааснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

Боловсролын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 27 ны өдрийн А.27 дугаартай тушаалын хоёрдугаар хавсралт

**Нэг. ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ
ҮНЭЛЭХ ШАЛГУУР**

№	Шалгуур	Шалгуурыг үнэлэх үзүүлэлт	Шалгуурт харгалзах онооны жин
1	Байгууллагын менежмент, удирдлагын манлайлал	- Цэцэрлэгийн дунд, богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн - Цэцэрлэгийн дотоод журмын хэрэгжилт, үр дүн - Цэцэрлэгийн удирдлагын (эрхлэгч, арга зүйч) зүгээс үзүүлсэн мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг, үр дүн - Цэцэрлэгийн удирдах ажилтны ёс зүйн хэм хэмжээ, манлайлал, байгууллагын соёл төлөвшүүлсэн байдал	15
2	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн	Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны үр дүн	25
3	Суралцагчийн хөгжил хамгаалал	- Хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлтийг бодитой үнэлж, баримт нотолгоо бүрдүүлж буй байдал - Хүүхдийг эрүүл ахуйн дадал хэвшилд сургах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажил, түүний үр дүн - Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүн	20
4	Хүний нөөцийн бодлого, багш ажилтны тасралтгүй хөгжил	- Багш, ажилтныг сонгон шалгаруулах болон ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэх үйл ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулсан байдал - Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүн	20
5	Сургалтын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлсэн байдал	Сургалтын орчны аюулгүй байдал	12
6	Эцэг эх, олон нийтийн оролцоо, түншлэл	Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчид, бусад байгууллагыг оролцуулж, хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажилласан байдал	8

**Хоёр. ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАГШИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР**

№	Үр дүнгийн үндсэн шалгуур	Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурыг тодорхойлох үзүүлэлт	Нийт оноо
1	Суралцагчийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагааны үр дүн	1.1.Сургалт, үйл ажиллагааны үр дүн 1.2.Цэцэрлэгийн анги танхимд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлж, осол гэмтэлгүй ажилласан ажлын үр дүн 1.3.Эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан ажлын үр дүн	55
2	Багшийн мэргэжлийн хөгжлийн үр дүн, оролцоо	2.1.Ажлын байранд мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, хамтран ажиллах, туршлагаа хуваалцах ажлын гүйцэтгэл, үр дүн 2.2.Сургалт, үйл ажиллагаанд хүүхдийн ялгаатай хэрэгцээг тооцон тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн бэлтгэж ашигласан ажлын үр дүн 2.3.Багшийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажилласан үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн 2.4.Байгууллага, олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон ажлын үр дүн	45

Боловсролын сайдын 2026 оны 04 дүгээр сарын 24 ны өдрийн А/Б/Г дугаартай тушаалын гуравдугаар хавсралт

Нэг. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

№	Шалгуур	Шалгуурыг үнэлэх үзүүлэлт	Шалгуурт харгалзах онооны жин
1	Байгууллагын менежмент, удирдлагын манлайлал	Сургуулийн дунд, богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн - Сургуулийн хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журам боловсруулах, багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх шийдвэр гаргахад талуудын оролцоог тэгш хангаж, хэрэгжилтэд үнэлгээ хийж ажилласан байдал - Сургалт, үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад захирал, сургалтын менежерийн оролцоо, багшид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх ажил, түүний үр дүн - Хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлж багш ажилтанд тэгш боломж олгосон байгууллагын соёл, удирдлагын ёс зүй төлөвшүүлсэн байдал	15
2	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн	Суралцагчийн сурлагын амжилтын үр дүн	30
3	Суралцагчийн хөгжил хамгаалал	Суралцагчийн хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үр дүн	15
4	Хүний нөөцийн бодлого, багш ажилтны тасралтгүй хөгжил	- Багш, ажилтныг сонгон шалгаруулах болон ажлын гүйцэтгэл үр дүнг үнэлэх үйл ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулсан байдал - Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн	20
5	Сургалтын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлсэн байдал	- Сургалтын орчин бүрдүүлэлт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, дотуур байр, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага, стандартын хэрэгжилтийн үнэлгээний үр дүн - Суралцахуйн түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий хүртээмжтэй, аюулгүй, хамгаалагдсан, хамтран суралцах сургалтын орчин бүрдсэн байдал - Суралцагчдад ээлтэй, эрүүл, аюулгүй, хамгаалагдсан, боловсрол эзэмших тэгш боломж бүхий сургалтын орчин бүрдүүлсэн байдал	15
6	Эцэг эх, олон нийтийн оролцоо, түншлэл	Сургууль хөгжүүлэх дунд, богино хугацааны төлөвлөлт, түүний хэрэгжилт, үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулахад эцэг, эх, асран хамгаалагч болон олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа, түншлэлийн ажлын үр дүн	5

**Хоёр.ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
БАГШИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУР**

№	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үр дүнгийн шалгуурыг тодорхойлох үзүүлэлт	Нийт оноо
1	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, ахиц, үр дүн	1.1.Суралцагчийн сурлагын амжилтын үр дүн	45
2	Суралцагчийг хөгжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагааны үр дүн	2.1.Сургалт үйл ажиллагаанд суралцагчийн ялгаатай хэрэгцээг тооцон төлөвлөж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн 2.2.Хүүхдийн төлөвшил, хичээлээс гадуурх сургалт үйл ажиллагааг төлөвлөн суралцагчийн авьяас сонирхлыг нээн хөгжүүлж буй байдал, үр дүн 2.3.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг зөвлөгөө, мэдээллээр хангаж хамтран ажилласан үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн	15
3	Багшийн мэргэжлийн хөгжлийн ахиц, үр дүн	3.1.Ажлын байранд мэргэжлийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлэх, бусад хамтран ажиллах, туршлагаа хуваалцах ажлын гүйцэтгэл, үр дүн 3.2.Сургалт, үйл ажиллагаанд технологи болон сургалтын нөөц хэрэглэгдэхүүн ашиглах мэдлэг, ур чадвараа хөгжүүлж, ашигласан үр дүн 3.3.Багшийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажилласан үйл ажиллагааны гүйцэтгэл үр дүн 3.4 Байгууллага, олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, үр дүн	40